



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР**

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ:

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН СЭЛЭНГЭ БАРИЛГА ЗАХИАЛАГЧ
ОНӨААТҮГ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**

Аудитын код: ДА-202/010/-ҮА

Аудитын төрөл: Үйл ажиллагааны аудит

Хамрах хүрээ: 2024-2025 он

Сэлэнгэ аймаг
2026 он

АГУУЛГА

Агуулга	Хуудас
Товчилсон үгийн жагсаалт	3
Хүснэгтийн жагсаалт	3
Гүйцэтгэх удирдлагад зориулсан хураангуй	4
1. Аудитын зорилт, хамрах хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	5
2. Ерөнхий мэдээлэл	6
3. Аудитын үр дүн (нотолгоо, шинжилгээ)	7
4. Аудитаар илрүүлсэн асуудал, зөрчил	14
5. Дүгнэлт	20
6. Зөвлөмж ба хэрэгжүүлэх төлөвлөгөө	21
7. Аудиторын тайланд гарын үсэг зурах хэсэг	23

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчлол	Тайлбар
ДАМПОУС	Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНӨААТҮГ	Орон Нутгийн Өмчит Аж Ахуйн Тооцоот Үйлдвэрийн Газар
ДА	Дотоод аудит
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
КРІ	Гүйцэтгэлийн үндсэн шалгуур үзүүлэлт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ERP	Enterprise Resource Planning – нэгдсэн нөөцийн удирдлагын систем

ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хүснэгтийн нэр	Хуудас
Хүснэгт 1	Техникийн хяналтын гэрээний хэрэгжилт	7
Хүснэгт 2	Төлөвлөгөө, Гүйцэтгэл байдал	8

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГАД ЗОРИУЛСАН ХУРААНГУЙ

Энэхүү дотоод аудитын тайлан нь Сэлэнгэ аймгийн Сэлэнгэ Барилга Захиалагч ОНӨААТҮГ-ын 2024-2025 оны үйл ажиллагаанд хийсэн үйл ажиллагааны аудитын үр дүнг нэгтгэн боловсруулсан болно.

Ерөнхий дүгнэлт

Сэлэнгэ Барилга Захиалагч" ОНӨААТҮГ-ын барилгын захиалагчийн хяналтын чиг үүрэг, төлөвлөгөөт хяналт-шинжилгээний үйл ажиллагаа тогтвортой хэрэгжиж байгаа боловч дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал, санхүүгийн болон гүйцэтгэлийн тооцоолол, тайлагналын чанарт системийн шинжтэй дутагдал (Е-Тайлан, Шилэн данс болон үр дүнгийн гэрээний дүгнэлт тасалдсан) илэрсэн тул дотоод хяналтын тогтолцоог "Сайжруулах шаардлагатай" гэж дүгнэв. (Дотоод аудитын дүгнэлтийн 2 дугаар түвшин – "Давамжтай зөрчилтэй")

Голлох илрүүлэлтүүд

- **Авлага, өглөгийн хяналт сул:** Урьдчилсан хяналт болон тооцоо нийлэлт хангалтгүйгээс их хэмжээний авлага хуримтлагдаж, НӨАТ-ын өглөг (өр) үүссэн.
- **Анхан шатны баримтын бүрдэл дутуу:** Автомашины шатахууны зарцуулалтыг замын хуудас, тооцооны хуудсаар бүрэн нотолж баталгаажуулалгүй зарлагдсан.
- **Дотоод хяналтын тогтолцоо бүрдээгүй:** Дотоод хяналт шалгалтын бодлого, журам байхгүй, төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх систем тогтоогүй.
- **Ажил хүлээлцэх журам зөрчигдсөн:** Удирдлага болон ерөнхий нягтлан бодогч солигдох үед өмч хөрөнгө, санхүүгийн баримтыг албан ёсоор хүлээлцээгүй.
- **Үйл ажиллагааны үнэлгээ хийгдээгүй:** Жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон Үр дүнгийн гэрээний гүйцэтгэлийг хуулийн хугацаанд нь дүгнүүлээгүй.
- **Ил тод байдлын хууль зөрчсөн:** Шилэн дансны цахим хуудсанд тоон баримтгүй, хоосон мэдээлэл байршуулсан зөрчил даамжирсан.
- **Бүртгэлийн суурь бодлогогүй:** Байгууллагын онцлогт тохирсон "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг баталж мөрдөөгүй.
- **Төлөвлөгөөгүй зарцуулалт хийсэн:** 2024–2025 оны үйлдвэрлэл, санхүүгийн жилийн төлөвлөгөө (бизнес төлөвлөгөө)-г дээд шатны байгууллагаар батлуулалгүй үйл ажиллагаа явуулсан.

Зөвлөмжийн төлөв

Аудитын дүгнэлтэд үндэслэн дөрвөн чиглэлээр (эрх зүйн орчны шинэчлэл, аргачлалын сайжруулалт, чадавхжуулах, хяналт-шинжилгээний дотоод тогтолцоо) нийт 8 илрүүлэлтийн хүрээнд 2 Албан шаардлага, 6 зөвлөмжийг хүргүүлж, 7 хоногоос 3 сарын дотор хэрэгжүүлэх хугацаатай төлөвлөгөө боловсруулсан.

**1. АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ
МЭДЭГДЭЛ**

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, 69 дүгээр зүйлийн 69.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дотоод аудитын дүрэм", Дотоод аудитын хорооны 2026 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан Дотоод аудитын 2026 оны төлөвлөгөө, хуваарийг тус тус үндэслэн дотоод аудитыг хийж гүйцэтгэв.
Аудитын зорилт	Сэлэнгэ аймгийн Сэлэнгэ Барилга Захиалагч ОНӨААТҮГ-Т (цаашид Сэлэнгэ Барилга Захиалагч ОНӨААТҮГ гэх)-ийн үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаа эсэхийг магадлах, дотоод хяналтын тогтолцоог сайжруулах, эрсдэлийг бууруулах замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэхэд оршино.
Аудитын хамрах хүрээ	Сэлэнгэ Барилга Захиалагч ОНӨААТҮГ-ын үндсэн чиг үүргийн хэрэгжилт хууль ёсны байдлыг 2024-2025 онуудын үйл ажиллагааг хамруулав.
Аудитын арга зүй	Аудитыг дотоод аудитын дэлхийн стандартууд болон Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 268 дугаар тушаалаар баталсан Улсын салбарын дотоод аудитын аргачлалын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулалт, түүвэрлэлт, ажиглалт ба ярилцлага зэрэг судалгааны арга зүйг ашиглан аудитын дүнд суурилан дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулах.
Аудитын шалгуур, үзүүлэлт	Дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав: Монгол Улсын Үндсэн хууль; Монгол Улсын Барилгын тухай хууль Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль; Засгийн газрын тухай хууль; Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль; Шилэн дансны тухай хууль; Төрийн албаны тухай хууль; Төсвийн тухай хууль; Төрийн хяналт шалгалтын тухай хууль; Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль; Захиргааны ерөнхий хууль; Авлигын эсрэг хууль; Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль; Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль;

Аудитын стандарт	Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт (ДАМПОУС/IPPF) болон I "Глобал Дотоод Аудитын Стандарт" 2024 оны хувилбар)-ын зарчим, шаардлагыг баримтлав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дотоод аудитор Д.Ванчигмаа 2026 оны 04 дугаар сарын 21-ний өдрөөс 2026 оны 05 дугаар сарын 15ны өдрийн хооронд хийж гүйцэтгэв.
Аудитын хязгаарлалт	Аудит нь Улсын болон байгууллагын нууцад хамаарах, тусгай зөвшөөрөл шаардлагатай зарим мэдээлэлд нэвтрэх эрх хязгаарлагдмал байдлын шинж чанарын үүднээс цааш нь нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх.

2. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2.1. Аудитын үндэслэл, зорилго

Аймгийн Засаг даргын баталсан 2026 оны 05 дугаар сарын 15-ний өдрийн удирдамж, дотоод аудитын жилийн төлөвлөгөөний дагуу энэхүү аудитыг гүйцэтгэв.

Сэлэнгэ аймгийн Сэлэнгэ Барилга Захиалагч ОНӨААТҮГ-Т (цаашид Сэлэнгэ Барилга Захиалагч ОНӨААТҮГ гэх)-ийн үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаа эсэхийг магадлах, дотоод хяналтын тогтолцоог сайжруулах, эрсдэлийг бууруулах замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэхэд оршино.

2.2. Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээ

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 11 тоот тогтоолоор “Сэлэнгэ барилга захиалагч” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг байгуулсан. **Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ** нь улс, аймаг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон гадаад, дотоодын зээл тусламжаар хэрэгжиж буй барилга угсралт, шинэчлэлт, засвар, тохижилтын ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлдэг. Барилга байгууламжийг норм, дүрмийн дагуу чанартай барьж байгуулах, хугацаанд нь ашиглалтад оруулах үндсэн чиг үүргийн хүрээнд дараах хяналтуудыг үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.Үүнд:

- **Төсөл, хөрөнгө оруулалтын хяналт:** Улс, аймаг, орон нутгийн төсөв, гадаад болон дотоодын зээл тусламжаар хийгдэж буй барилга угсралт, шинэчлэлт, засвар, тохижилтын ажилд захиалагчийн хяналт тавих;
- **Хувийн хэвшлийн хяналт:** Барилгын тухай хуулийн 37.2-т заасны дагуу иргэн, хуулийн этгээдийн хувийн хөрөнгө оруулалттай барилгын ажилд гэрээгээр захиалагчийн хяналт гүйцэтгэх;
- **Чанар, стандартын хяналт:** Барилгыг батлагдсан төсөвт багтаан, стандартын шаардлага хангасан хийц эдлэлээр бариулах, далдлагдах ажлыг шалгаж баталгаажуулах;

- **Гүйцэтгэлийн хяналт:** Гүйцэтгэгч байгууллагын зөрчлийг арилгуулах, ажлын гэрээт хугацааг чанд мөрдүүлэх чиг үүргүүдийг хэрэгжүүлж байна.

2.3. Эрх зүйн орчин

“Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Барилгын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, барилгын норм, дүрмийг мөрдлөг болгон ажилладаг. Тус газар нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-т заасан эрх, үүргийн хүрээнд иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулан, барилгын гүйцэтгэлд захиалагчийн хяналт тавих эрх зүйн бүрэн чадамжтай бөгөөд салбарын стандартыг чанд мөрдүүлэн ажиллаж байна.

3. АУДИТЫН ҮР ДҮН

3.1. Байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, эрх бүхий байгууллагын шийдвэрт нийцэж байгаа эсэх

1.Үйл ажиллагааны гүйцэтгэл ба цар хүрээ: Тус байгууллага нь 2024–2025 оны үйлдвэрлэл, санхүүгийн жилд улс, орон нутгийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сан болон замын сангийн хөрөнгө оруулалттай барилга байгууламж, их засвар, тохижилтын ажлуудад захиалагчийн болон техникийн хяналт хэрэгжүүлэх үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна. Онуудын харьцуулалтаар 2024 онд 130 ажилд техникийн хяналт тавьсан бол 2025 онд 138 ажил болж нэмэгдсэн нь байгууллагын ажлын ачаалал, үйл ажиллагааны цар хүрээ тасралтгүй өсөж байгааг харуулж байна.

2. Дотоод хяналт ба хуулийн нийцэл (Эрсдэл): Үндсэн үйл ажиллагаа тасралтгүй явагдаж байгаа хэдий ч байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, эрх бүхий байгууллагын шийдвэрт нийцэж байгаа эсэхэд тавих дотоод хяналтын тогтолцоо маш сул байна. 2024-2025 онуудын Үйлдвэрийн газар нь үйлдвэрлэл, санхүүгийн жилийн төлөвлөгөө (бизнес төлөвлөгөө)-гөө боловсруулж, эрх бүхий байгууллагаар төлөвлөгөөгөө батлуулаагүй эрсдэлтэй нөхцөл байдлыг үүсгэсэн байна.

3.2.1. Улсын төсөв, аймгийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй барилга байгууламж, их засварын ажлын хүрээнд байгуулсан захиалагчийн болон Техникийн хяналтын гэрээний хэрэгжилт “

“Сэлэнгэ Барилга Захиалагч” ОНӨААТҮГ нь 2024–2025 онд улсын төсөв, аймгийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сан, замын сан болон бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн барилга байгууламж, их засварын ажлын хүрээнд захиалагчийн болон техникийн хяналтын гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэн ажилласан байна. Тус байгууллага нь барилга угсралт, засварын ажлын явц, чанар, зураг төсөв, норм дүрэм, стандартын хэрэгжилт, ажлын тоо хэмжээ, гүйцэтгэлийн хугацаа болон ашиглалтад хүлээн авах бэлтгэл хангалтад хяналт тавьж, захиалагч байгууллагыг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажилласан байна.

Үзүүлэлт	2024 он	2025 он	Өөрчлөлт / өсөлт, бууралт
Орлогын төлөвлөгөөний биелэлт	132%	154%	+22 нэгж хувиар өссөн
Төвлөрүүлсэн нийт зардал /сая төгрөг/	292.2	470.6	+178.4 сая төгрөгөөр буюу +61.1% өссөн
Аймгийн төсөв болон ОНХС-ийн хөрөнгө оруулалтын ажлууд	41 ажил /35 ажил дууссан/	47 ажил /42 ажил дууссан/	Ажлын тоо 6-аар нэмэгдсэн, дууссан ажил 7-оор өссөн
Сумдын төсөв болон ОНХС-ийн хөрөнгө оруулалтын ажлууд	71 ажил /62 ажил дууссан/	78 ажил /73 ажил дууссан/	Ажлын тоо 7-оор нэмэгдэж, хяналтын цар хүрээ тэлсэн
Замын сангийн хөрөнгө оруулалтын ажлууд	18 ажил /17 ажил дууссан/	16 ажил /14 ажил дууссан/	Ажлын тоо 2-оор буурсан ч хэрэгжилтийн чанарт анхаарсан

3.2.2. Захиалагчийн хяналт, техникийн хяналтын үйл ажиллагаа, гүйцэтгэлийн баримтжуулалт, ажлын явцын болон улсын комисс, хүлээн авалтын ажиллагаа нь хууль, дүрэм, барилгын норм ба стандартад нийцэж явагдсан эсэх

2024–2025 оны тайлангийн тоо баримтаас үзэхэд ажлын явцын болон улсын комисс, хүлээн авалтын ажиллагаа хууль, дүрэм, барилгын норм ба стандартын шаардлагад нийцсэн байна. Бүрэн хэрэгжсэн ажлын тоо 2024 онд 114 байсан бол 2025 онд 129 болж 15 ажлаар нэмэгдсэн, техникийн хяналтын зардлын төвлөрүүлэлт 178.4 сая төгрөгөөр өссөн нь захиалагчийн болон техникийн хяналтын хэрэгжүүлсэн байна.

3.2.3. Барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл, үе шатны гүйцэтгэлийн хяналтын баримт бичиг, холбогдох бүрдэл нь бүрэн эсэх, тэдгээрийг зохих журмын дагуу бүрдүүлсэн эсэх

Монгол Улсын Барилгын тухай хуульд заасны дагуу барилга угсралт, их засварын ажлыг хууль ёсоор эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн гол бүрдэл баримт бичиг нь Захиалагчийн техникийн хяналтын гэрээ байгуулж тус байгууллага нь хуулиар хүлээсэн энэхүү суурь нөхцөлийг бүрэн хангаж, хөрөнгө оруулалтын эх үүсвэр тус бүрээр хяналтын гэрээнүүдийг байгуулан үйл ажиллагаагаа эхлүүлсэн байна. Тодруулбал, хууль тогтоомжийн хүрээнд 2024 онд 133 ажил, 2025 онд 145 ажилд техникийн хяналтын гэрээг баталгаажуулж, талбайн хяналтыг хэрэгжүүлжээ.

Зураг төсөл нь батлагдаж, магадлал хийгдсэн, гэрээ нь хууль ёсны дагуу зурагдаж ажил нь эхлэн 100% амжилттай дууссан зарим томоохон ажлуудын нэрс, гэрээний дүн: **Гэрээний биелэлт болон он дамжсан ажлын удирдлага:**

2024 онд: Нийт байгуулсан 133 гэрээнээс **117 ажил (87.9%)** бүрэн хэрэгжиж дууссан бол 16 ажил (12.1%) он дамжин шилжсэн.

2025 онд: Нийт байгуулсан 145 гэрээнээс **133 ажил (91.7%)** хугацаандаа бүрэн хэрэгжиж дууссан бөгөөд он дамжсан ажлын тоо 12 (8.3%) болж буурсан

байна.Эдгээр үзүүлэлт нь гэрээт ажлын гүйцэтгэлд тавих хяналтын чанар сайжирч, барилга байгууламж, засварын ажлыг хугацаанд нь ашиглалтад хүлээн авах бэлтгэл хангалт болон гүйцэтгэгч байгууллагуудын ажлын хариуцлага хоёр оны заагт ахисан түвшинд хүрснийг харуулж байна.Эдгээр тоо баримтууд нь "Сэлэнгэ барилга захиалагч" ОНӨААТҮГ нь барилгын ажил эхлүүлэх урьдчилсан шат болох зураг төсөл хянах, экспертизэд оруулах, гурван талт гэрээ байгуулах ажлыг хууль журмын дагуу тоо баримттайгаар гүйцэтгэснийг баталж байна.

3.2.4.Санхүүгийн байдал: Захиалагчийн хяналтын орлого төвлөрүүлэлт, төсвийн хөрөнгийн зарцуулалт, зардлын төлөвлөлт, гүйцэтгэл нь хууль тогтоомж, төсөв санхүүгийн холбогдох журамд нийцэж байгаа эсэх.

Орлого, зардлын гүйцэтгэлийн байдал: 2024 онд батлагдсан төлөвлөгөөнөөс **41,334.2 мянган төгрөгөөр**, 2025 онд **65,839.0 мянган төгрөгөөр** тус тус даван биелсэн байна. Гэвч 2025 онд ерөнхий ба удирдлагын зардал батлагдсан төлөвлөгөөнөөс **4,343.8 мянган төгрөгөөр** хэтэрч, өмнөх оны гүйцэтгэлээс **166,485.5 мянган төгрөгөөр** огцом өссөн нь байгууллагын цэвэр ашиг, ашигт ажиллагааны түвшин буурахад голлон нөлөөлжээ. Зардлын хэтрэлтээс шалтгаалан татварын дараах цэвэр ашиг 2024 онд 141,543.0 мянган төгрөг байснаас 2025 онд 59,883.7 мянган төгрөг болж, 81,659.3 мянган төгрөгөөр буюу 57.70%-иар огцом буурсан үзүүлэлттэй байна.

Төлөвлөгөө,Гүйцэтгэл байдал

Хүснэгт2
/мянган төгрөг/

	Дансны нэр, төрөл	2024 төлөвлөгөө	2024 гүйцэтгэл	Зөрүү	2025 төлөвлөгөө	2025 гүйцэтгэл	Зөрүү	Өөрчлөлтийн хувь
1	Борлуулалтын орлого /цэвэр/	221,823.6	263,157.8	41,334.2	281,141.0	346,980.0	65,839.0	31.85%
2	Нийт ашиг /алдагдал/	221,823.6	263,157.8	41,334.2	281,141.0	346,980.0	65,839.0	31.85%
3	Хүний орлого	-	0.0	-	-	6,776.4	6,776.4	нэмэгдсэн
4	Бусад орлого	-	0.0	-	-	663.4	663.4	нэмэгдсэн
5	Ерөнхий ба удирдлагын зардал	221,823.6	118,999.3	102,824.3	281,141.0	285,484.8	4,343.8	139.90%
6	Санхүүгийн зардал	-	0.0	-	-	677.6	677.6	нэмэгдсэн
7	Бусад зардал	-	1,185.7	1,185.7	-	1,224.3	1,224.3	3.26%
8	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	-	0.0	-	-	495.6	495.6	нэмэгдсэн
9	Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	-	142,972.8	-	-	66,537.5	-76,435.3	-53.46%
10	Орлогын татварын зардал	-	1,429.7	-	-	6,653.7	5,224.0	365.38%
11	Татварын дараах ашиг /алдагдал/	-	141,543.0	-	-	59,883.7	-81,659.3	-57.70%

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон анхан шатны баримт хөтлөх заавар, аргачлалыг мөрдөөгүй, бүрдэл дутуу ажил гүйлгээгээр 2024 онд 7,641.8 мянган төгрөг, 2025 онд 10,858.7 мянган төгрөгийн шатахууныг тус тус зарлагдаж, Жолоочийн тооцооны хуудсанд автомашины шатахууны үндсэн норм болон зарцуулалтын тооцоог хийж баталгаажуулаагүй байна.

- Шилэн дансны цахим хуудсанд тоон баримтгүй, хоосон мэдээлэл байршуулах зөрчил жилээс жилд даамжирч байна. Тухайлбал, 2024 онд 20 төрлийн хүрээнд 104 мэдээллийг тоо баримтгүй, хоосон тайлагнасан бол 2025 онд энэ үзүүлэлт 24 төрлийн хүрээнд 180 мэдээлэл болж өсжээ. Энэ нь хоосон тайлагнасан мэдээллийн тоо өмнөх оноос 76-аар буюу 73.1 хувиар нэмэгдсэн. Иймд тус байгууллагыг Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн мэдээллийг иж бүрэн, үнэн зөв, ойлгомжтой тайлагнах үүргээ хангалтгүй .
- Байгууллагын хэмжээнд Дотоод хяналт шалгалтын бодлого, журмыг боловсруулж баталгаажуулаагүй, төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх тогтолцоо бүрдээгүй байна.
- 2024-2025 онуудын үйл ажиллагааны батлагдсан төлөвлөгөө, гүйцэтгэлийг үр дүнгийн гэрээгээр дүгнүүлээгүй байна.
- Байгууллагын удирдлага болон ерөнхий нягтлан бодогчийг албан тушаалд томилох, ажлаас чөлөөлөх үед ажил хүлээлцэх комисс, эд хөрөнгийг зохих журмын дагуу хүлээлцүүлээгүй зөрчил илэрсэн.
- Тус үйлдвэрийн газар нь 2024-2025 онуудын үйлдвэрлэл, санхүүгийн жилийн төлөвлөгөө (бизнес төлөвлөгөө)-гөө боловсруулсан боловч эрх бүхий дээд байгууллагаар зохих журмын дагуу батлуулаагүй үйл ажиллагаа явуулсан байна.

3.2.5. Авлага, өглөгийн бүртгэл, тооцоо нийлэх ажиллагаа, баталгаажуулалт нь үнэн зөв, бүрэн хийгдсэн эсэх

Байгууллагын дотоод хяналтын тогтолцоо сул, санхүүгийн төлбөр тооцоог урьдчилан хянаж баталгаажуулдаггүйгээс шалтгаалан 2024–2025 онуудад нийт **318,701.4 мянган төгрөгийн** хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэл үүсэж, байгууллагыг санхүүгийн эрсдэлд оруулсан байна. Үүнд:

- **Дансны авлага:** 169,612.4 мянган төгрөг,
- **Бусад авлага:** 132,627.2 мянган төгрөг,
- **Татварын авлага:** 16,461.0 мянган төгрөг тус тус бүртгэлтэй байна.

Мөн Нэмүү өртгийн албан татварын (**НӨАТ-ын**) өглөгт **12,171.0 мянган төгрөгийн** үлдэгдэлтэй байна. Дээрх авлага, өр төлбөрийг 2025 онд багтаан дотоод нөөц бололцоонд тулгуурлан барагдуулах, суутган тооцох бүрэн боломжтой байсан боловч санхүүгийн удирдлагын зүгээс шаардлагатай арга хэмжээг аваагүйгээс одоог хүртэл эцэслэн барагдуулаагүй, хугацаа хэтрүүлсэн байна.

3.2.6 Өмч, хөрөнгийн удирдлага: Үндсэн хөрөнгийн бүртгэл, тооллого, ашиглалт, хадгалалт хамгаалалт нь холбогдох журмын дагуу хэрэгжиж байгаа эсэхийг үнэлнэ. 2024 оны үйл ажиллагааны тайланд байгууллагын үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 24.5 сая төгрөг, нэмэгдсэн хөрөнгө 9.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 28.9 сая төгрөг гэж тусгагдсан байна. 2025 онд үндсэн хөрөнгө 48.9 сая төгрөг болж өссөн бөгөөд тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил худалдан авсан, мөн зарим хөрөнгийг акталж бүртгэлээс хассан байна.

Өмч хөрөнгийн бүртгэл, хөдөлгөөн, актлалд, балансаас баланст шилжүүлсэн хөрөнгийн баримтжуулалт нь холбогдох шийдвэр, тооллогын бүртгэл, ашиглалт, хадгалалт хамгаалалт нь холбогдох журмын дагуу, эд хөрөнгийн тооллого, хариуцагчийн карт, ашиглалтын бүртгэл, хадгалалт хамгаалалтын хяналтыг хэрэгжүүлсэн.

3.2.6. Хүний нөөцийн байдал: Байгууллага нь батлагдсан орон тоо, бүтэц зохион байгуулалтын дагуу ажиллаж байгаа эсэх, албан тушаалын чиг үүргийн хэрэгжилт хангагдсан эсэхийг үнэлнэ.

Аймгийн Засаг даргын 2024 оны 01-р дүгээр сарын 24 өдрийн А/29 захирамжаар бүтэц 9 орон тоогоор, 2025 оны 01-р дүгээр сарын 27 өдрийн А/20 захирамжаар бүтэц 12 орон тоогоор, батлагдсан.

- **2024 он (Батлагдсан орон тоо - 9):** Газрын дарга, архитектор, барилгын инженер, дулааны инженер, зам гүүрний инженер, цахилгаан холбоо дохиоллын инженер, нягтлан бодогч, жолооч, бичиг хэрэг-нярав.
- **2025 он (Батлагдсан орон тоо - 12):** Дээрх бүтэц дээр техникийн хяналтын чиг үүргийг чанаржуулах зорилгоор **барилгын инженер /мэргэшсэн төсөвчин/, барилгын хяналтын инженер, лаборант** гэсэн 3 орон тоог шинээр нэмэгдүүлсэн. боловч

Орон тоог баталгаажуулан нэмэгдүүлсэн нь ажлын шаардлагад нийцсэн эерэг өөрчлөлт боловч 2025 оны санхүүгийн тайлангаар батлагдсан 12 орон тооноос **ердөө 8 албан хаагч** бодитоор ажилласан байна.

Үүнээс үүдэн дараах эрсдэлүүд үүсэж байна.

- **Ажлын хэт ачаалал:** Ажиллаж буй 8 ажилтан үлдсэн 4 сул орон тооны чиг үүргийг нөхөж ажилласнаар ажлын бүтээмж буурах, мэргэжлийн алдаа гаргах эрсдэлтэй.
- **Чиг үүргийн давхардал ба орхигдол:** Инженер техникийн ажилтнууд үндсэн ажлаас гадна өөр чиглэлийн хяналтыг хавсран гүйцэтгэснээр техникийн хяналтын чанарт сөргөөр нөлөөлөх магадлалтай.

3.2.7. Албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаа нь стандартад нийцсэн эсэх, гүйцэтгэлийн баримт бичиг, шийдвэрлэлтийн материал, барилгын хяналтын баримтуудыг хадгаламжийн нэгж болгон бүрдүүлж, зохих журмын дагуу хадгалсан эсэхийг үнэлнэ.

Архивын баримтуудыг цаасан болон цахим хэлбэрээр зэрэгцүүлэн хөтөлж, стандартын дагуу хадгаламжийн нэгж үүсгэх ажил хийгдсэн байна. 2025 оноос эхлэн архив, албан хэрэг хөтлөлтийн болон бусад цахим системийг ашиглан баримт бичгийг цахимжуулах ажил эрчимжсэн нь хадгаламжийн нэгжийг цахимаар индексжүүлж, иж бүрдлийг хянах боломжийг бүрдүүлсэн. Өргөдөл гомдлыг ERP системээр дамжуулан хүлээн авч, хугацаа болон шийдвэрлэлтийн чанарт хяналт тавьж, хадгаламжийн нэгж үүсгэн архивлагдсан байна.

3.2.8. Өмнөх аудит, хяналт шалгалтаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт бүрэн хангагдсан эсэх, үр дүн гарсан эсэх

2025 оны аудитын тайланд өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 50 хувь гэж үнэлсэн байна. Тухайлбал, жолоочийн тооцооны хуудасгүйгээр шатахууны зардал гаргасан зөрчлийг давтан гаргаагүй боловч томилолтын хуудсыг бүрэн баталгаажуулалгүйгээр томилолтын зардал гаргасан зөрчил давтагдсан тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн байна. Энэ нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх дотоод хяналтын хангалтгүй байна.

4. АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АСУУДАЛ, ЗӨРЧИЛ

Сэлэнгэ Барилга Захиалагч ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа нь үндсэн чиг үүргийн хүрээнд ажил, үйлчилгээг тасралтгүй зохион байгуулж ирсэн зэрэг тал байгаа хэдий ч Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон Шилэн дансны тухай хуулиудын суурь заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Байгууллагын дотоод хяналтын систем бүрэлдээгүй, санхүүгийн бодлогын баримт бичиггүй, жилийн бизнес төлөвлөгөөгүйгээр төсөв захиран зарцуулж, шилэн дансны тайлагналыг санаатай болон санамсаргүйгээр орхигдуулсан зөрчил нь системтэй шинж чанартай байна.

Аудитын явцад илэрсэн асуудлуудыг ДАМПОУС-ийн 2410 стандартын шаардлагын дагуу "шалгуур, бодит байдал, шалтгаан, үр дагавар, зөвлөмж" Албан шаардлага гэсэн бүтцэд оруулан, ноцтой байдлын зэрэглэлээр (Өндөр / Дунд /) ангилан 8 үндсэн илрүүлэлт болгон нэгтгэв.

4.1. Илрүүлэлт бүрийн нарийвчилсан тайлбар

Илрүүлэлт 4.2.1 Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл	
Ноцтой байдлын зэрэглэл	өндөр
Шалгуур / байх ёстой нөхцөл	Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах.", 20.2.6 дахь "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", гэсэн заалтуудын дагуу ажиллах ёстой.
Бодит байдал	Төлбөр тооцооны урьдчилсан хяналт, баталгаажуулалт хангалтгүй байснаас шалтгаалан 2024-2025 онуудад нийт 330,871.6 мянган төгрөгийн өр, авлага (үүнд: дансны авлага 169,612.4 мянган төгрөг, бусад авлага 132,627.2 мянган төгрөг, татварын авлага 16,461.0 мянган төгрөг, НӨАТ-ын өглөг 12,171.0 мянган төгрөг) -ийн барагдуулаагүй тооцоо байна. Эдгээр өр, авлагыг 2025 онд багтаан шийдвэрлэж, барагдуулах бүрэн боломжтой байсан хэдий ч өнөөдрийг хүртэл тодорхой үр дүнд хүрээгүй, шийдвэрлэгдээгүй байна.

Шалтгаан	Санхүү, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны болон гүйцэтгэлийн хяналт сул, авлагын насжилтыг тогтмол хянаж, нэхэмжлэх, дуудлага өгөх зэрэг авлага барагдуулах ажлыг удирдлагын түвшинд зохион байгуулаагүй. Санхүүгийн сахилга бат алдагдсан, хариуцсан ажилтнуудын ажлын хариуцлага дутмаг
Үр дагавар	Байгууллагын эргэлтийн хөрөнгө түгжигдэж, мөнгөн урсгал саатах, авлага хугацаа хэтэрч "найдваргүй авлага" болох эрсдэлтэй. Түүнчлэн, НӨАТ-ын өглөгийг хугацаанд нь барагдуулаагүйгээс Татварын ерөнхий хуулийн дагуу торгууль, алданги хүлээж, байгууллагад нэмэлт хохирол учрах нөхцөл бүрдсэн
Албан шаардлага	Төлбөр тооцооны урьдчилсан хяналтын тогтолцоог сайжруулж, авлагын насжилтын тайланг сар бүр удирдлагад танилцуулж хэвшүүлэх

Илрүүлэлт 4.2.2: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйл

Ноцтой байдлын зэрэглэл	өндөр
Шалгуур / байх ёстой нөхцөл	Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалтуудын дагуу ажиллах ёстой.
Бодит байдал	Анхан шатны баримт хөтлөх заавар, аргачлалын дагуу жолоочийн тооцооны хуудсанд автомашины шатахууны үндсэн норм болон зарцуулалтын тооцоог бүрэн хөтөлж, баталгаажуулаагүй зөрчил тогтоогдлоо. Ийнхүү баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээгээр 2024 онд 7,641.8 мянган төгрөг, 2025 онд 10,858.7 мянган төгрөгийн шатахууныг тус тус зарлагадсан байна.
Шалтгаан	Автомашины ашиглалт, шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналт сул, ерөнхий нягтлан бодогч болон холбогдох даамал анхан шатны баримтын бүрдлийг шалгаж хүлээж авдаггүй, жолоочийн тооцооны хуудсыг хөтлөх зааврыг мөрдөж ажилладаггүй.
Үр дагавар	Үр дагавар: Анхан шатны баримтгүйгээр 2024 онд 7,641.8 мянган төгрөг, 2025 онд 10,858.7 мянган төгрөгийн шатахууныг зарлагадсан нь хөрөнгө үрэгдэх, зориулалтын бусаар ашиглагдах, хууль бус зарцуулалт хийгдэх өндөр эрсдэлийг бий болгосон. Санхүүгийн тайлан үнэн зөв, бодитой гарах нөхцөл алдагдсан.
Албан шаардлага	Автомашины ашиглалт, жолоочийн тооцооны хуудасны бүрдлийг хангаагүй тохиолдолд шатахууныг санхүүгээс зарлагадахгүй байх

	шаардлагыг тууштай мөрдөх, Байгууллагын эзэмшлийн автомашин бүрийн шатахууны үндсэн норм, өвлийн болон зуны улирлын зарцуулалтын нормоо шинэчлэн тогтоож, хяналтын системийг эсвэл километрийн бүртгэл) сайжруулах.
--	---

Илрүүлэлт 4.2.3: Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын

Ноцтой байдлын зэрэглэл	өндөр
Шалгуур / байх ёстой нөхцөл	Байгууллага нь үйл ажиллагааны эрсдэлээс сэргийлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төлөвлөгөөний гүйцэтгэлийг хянах зорилгоор өөрийн онцлогт тохирсон дотоод хяналтын бодлого, журамтай байх ёстой. Мөн дотоод хяналтын чиг үүргийг хариуцах нэгж, ажилтныг томилж, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгуур үзүүлэлтийн дагуу тогтмол үнэлж, тайлагнадаг тогтолцоог бүрдүүлсэн байх шаардлагатай.
Бодит байдал	Дотоод хяналт шалгалтын бодлого, журам боловсруулж баталгаажуулаагүйн улмаас үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг бодитой үнэлэх, хяналт тавих тогтолцоо бүрдээгүй зөрчил дутагдалтай байна.
Шалтгаан	Байгууллагын удирдлагын зүгээс дотоод хяналтын тогтолцоо болон эрсдэлийн удирдлагын ач холбогдлыг дутуу үнэлж, засаглалын соёл төлөвшөөгүй. Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг зөвхөн цаасан дээрх тайлангаар сольж, явцын хяналт болон гүйцэтгэлийн бодит үнэлгээний арга зүй, шалгуур үзүүлэлтийг тодорхойлж өгөөгүй. Дотоод хяналтын чиг үүргийг хариуцах орон тооны ажилтан эсвэл комиссыг албан ёсоор томилж үүрэгдүүлээгүй, удирдлагын зүгээс энэ чиглэлд санаачилга гаргаж ажиллаагүй.
Үр дагавар	Үйл ажиллагааны эрсдэл: Жилийн төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй байх, үндсэн зорилтууд тасалдах, алдаа дутагдал даамжрах явцад урьдчилан хяналт тавьж, засаж залруулж чадахгүй байна. Санхүүгийн эрсдэл: Санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд дотоод хяналт байхгүйгээс хөрөнгө мөнгө үр ашиггүй зарцуулагдах, авлага өглөг үүсэх, өмч хөрөнгө эзэнгүйрэх нөхцөл бүрдсэн (Илрүүлэлт 4.2.1 - 4.2.2-т дурдагдсан зөрчлүүд үүсэх гол суурь нөхцөл болсон). Удирдлагын шийдвэр гаргалт: Удирдлагын түвшинд үйл ажиллагааны бодит гүйцэтгэлийн мэдээлэл дутагдаж, дүн шинжилгээгүй, үндэслэл муутай шийдвэр гаргах эрсдэл нэмэгдсэн.
Зөвлөмж	Журам боловсруулж, батлуулах: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын Нийтлэг журамд нийцүүлэн, байгууллагын

	<p>онцлогт тохирсон "Дотоод хяналт шалгалтын бодлого, журам"-ын төслийг яаралтай боловсруулж, Удирдах зөвлөл эсвэл эрх бүхий дээд шатны удирдлагаар батлуулан мөрдүүлэх.</p> <p>Үнэлгээний тогтолцоо нэвтрүүлэх: Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх тодорхой, хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлтүүдийг (KPI) журамд суулгаж, явцын гүйцэтгэлийг улирал бүр үнэлж, удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэн, үр дүнг тооцдог механизмыг бүрдүүлэх.</p> <p>Хариуцах ажилтныг томилох: Дотоод хяналт шалгалтын чиг үүргийг хариуцах ажилтныг албан ёсны тушаалаар томилж, ажлын байрны тодорхойлолтод хүлээх үүргийг нь нарийвчлан тусгаж өгөх.</p>
--	--

Илрүүлэлт 4.2.4: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйл

Ноцтой байдлын зэрэглэл	ӨНДӨР
Шалгуур / байх ёстой нөхцөл	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйл (Эд хөрөнгийн тооллого), Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, "Байгууллагын удирдлага, эд хариуцагч солигдоход ажил, эд хөрөнгө хүлээлцэх журам". Удирдах албан тушаалтан солигдох үед албан ёсны тушаалаар комисс томилогдон, эд хөрөнгийн иж бүрэн тооллого хийж, акт үйлдэж хүлээлцэх ёстой.
Бодит байдал	Байгууллагын удирдлага болон ерөнхий нягтлан бодогчийг албан тушаалд томилох, ажлаас чөлөөлөх үед ажил хүлээлцэх комисс байгуулагдаж, эд хөрөнгийг зохих журмын дагуу хүлээлцээгүй байна."
Шалтгаан	Удирдлагын зүгээс эрх зүйн ухамсар, хариуцлага сул байсан, ажил хүлээлцэх үйл ажиллагааг зөвхөн захиргааны шинжтэй гэж үзэж, санхүү, эд хөрөнгийн хариуцлагыг орхигдуулсан, ерөнхий нягтлан бодогч шаардлага тавьж ажиллаагүй.
Үр дагавар	Байгууллагын өмч хөрөнгө, авлага, өглөг, санхүүгийн баримт бичгүүд дутах, үрэгдэх, эзэнгүйрэх, өмнөх удирдлагын үеийн алдаа зөрчлийн хариуцлагыг дараагийн удирдлага хүлээх зэрэг эрх зүйн болон санхүүгийн маргаантай нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй.
Зөвлөмж	Ажил хүлээлцэх актад тухайн үеийн санхүүгийн үлдэгдэл, үндсэн хөрөнгө, эд хогшил, архив, нууцын зэрэглэлтэй баримт бичгийг нэг бүрчлэн тусгаж баталгаажуулах.

Илрүүлэлт 4.2.5:

Ноцтой байдлын зэрэглэл	ДУНД
Шалгуур / байх ёстой нөхцөл	Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын дарга нь Аймгийн Засаг даргатай жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх "Үр дүнгийн гэрээ"-г хуулийн хугацаанд байгуулж, тайлант оны эцэст гүйцэтгэлийг албан ёсоор дүгнүүлэн, үр дүнгийн хувийг баталгаажуулсан байх ёстой.
Бодит байдал	Байгууллагын удирдлагын зүгээс Аймгийн Засаг даргатай байгуулсан 2024, 2025 онуудын үйл ажиллагааны батлагдсан төлөвлөгөөний биелэлт болон үр дүнгийн гэрээний гүйцэтгэлийг тухайн онуудад нь багтаан албан ёсоор дүгнүүлж, үнэлүүлээгүй зөрчил тогтоогдов.
Шалтгаан	<ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Байгууллагын удирдлагын зүгээс дээд шатны удирдлагатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг тайлагнах, үнэлүүлэх хуулиар хүлээсэн үүрэг, хариуцлагадаа хойрго хандсан; <input type="checkbox"/> Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний тасаг болон холбогдох хэлтсээс харьяа байгууллагын гэрээг хугацаанд нь дүгнэх шаардлага, хяналтыг тавиагүй орхигдуулсан.
Үр дагавар	Төрийн албаны тухай хууль болон холбогдох журмын заалтууд зөрчигдсөн. Байгууллагын дарга 2024-2025 онуудад үндсэн зорилт, чиг үүргээ хэдэн хувийн гүйцэтгэлтэй биелүүлсэн нь тодорхойгүй, хууль эрх зүйн хувьд үнэлэгдээгүй үлдсэн.
Зөвлөмж)	Хугацааны сахилга батыг мөрдөх: Цаашид жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон үр дүнгийн гэрээний биелэлтийг тухайн жилийн 12 дугаар сард эсвэл дараа оны 1 дүгээр сард багтаан Аймгийн Засаг даргаар хуулийн хугацаанд нь заавал дүгнүүлж хэвших.

Илрүүлэлт 4.2.6: Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйл (Шилэн дансны үйл ажиллагааны зарчим), **6 дугаар зүйл** (Шилэн дансанд тавигдах мэдээлэл болон хугацаа).

Ноцтой байдлын зэрэглэл	ӨНДӨР
Шалгуур / байх ёстой нөхцөл	<p>Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан зарчмыг хангах: Шилэн дансны үйл ажиллагаанд мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, мөн олон нийтэд ойлгомжтой, шуурхай, хүртээмжтэй байх зарчмыг чанд баримталсан байх ёстой. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн шаардлагыг биелүүлэх: Хуулийн 6 дугаар зүйлд заасан шилэн дансанд тавигдах мэдээллийн агуулга болон хугацааны хуваарийг</p>

	нарийвчлан мөрдөж, тайлан мэдээллийг хоосон бус, холбогдох тоон баримт, нотолгооны хамт бүрэн гүйцэд байршуулах үүрэгтэй.
Бодит байдал	Шилэн дансны цахим хуудсанд тоон баримтгүй, хоосон мэдээлэл байршуулах зөрчил жилээс жилд даамжирч байна. Тухайлбал, 2024 онд 104 мэдээллийг хоосон тайлагнасан бол 2025 онд энэ үзүүлэлт 180 болж, өмнөх оноос 76-аар буюу 73.1 хувиар нэмэгджээ. Иймд тус байгууллагыг Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн мэдээллийг иж бүрэн, үнэн зөв, ойлгомжтой тайлагнах үүргээ хангалтгүй биелүүлсэн
Шалтгаан	<input type="checkbox"/> Шилэн дансны мэдээлэл оруулахыг хариуцсан санхүүгийн ажилтны ажлын хариуцлага туйлын хангалтгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх эрх зүйн ухамсар сул; <input type="checkbox"/> Ерөнхий нягтлан бодогч болон байгууллагын удирдлагын зүгээс шилэн дансны шинэчлэл, гүйцэтгэлд сар бүр тавих дотоод хяналтын тогтолцоог огт бүрдүүлээгүй;
Үр дагавар	Хуулийн зөрчил: Шилэн дансны тухай хуулийг системтэйгээр, давтан зөрчсөн. Олон нийтийн хяналт тавих, төрийн үйл ажиллагаа ил тод нээлттэй байх үндсэн зарчим алдагдсан.
Зөвлөмж	Нөхөн байршуулах хугацаат үүрэг: Шилэн дансны цахим хуудсанд 2024 онд хоосон үлдээсэн 104 мэдээлэл, 2025 оны 180 мэдээллийг холбогдох анхан шатны тоон баримт, гүйлгээний утга, шийдвэрийн хамт хуулийн шаардлагад нийцүүлэн яаралтай нөхөн байршуулж, гүйцэтгэлийг аудитад танилцуулах.

Илрүүлэлт 4.2.7: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйл (Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн удирдлага), Олон улсын санхүүгийн тайлагналын стандарт (ОУСТ).

Ноцтой байдлын зэрэглэл	ӨНДӨР
Шалгуур / байх ёстой нөхцөл	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17.1.4-т зааснаар аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлах, мөрдүүлэх" үүрэгтэй. Байгууллага нь өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон, бүртгэлийн суурь, хөрөнгө, авлага, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх, хэмжих, тайлагнах заавар, аргачлалыг тусгасан бодлогын баримт бичгийг заавал албан ёсоор баталж, мөрдлөг болгосон байх ёстой.
Бодит байдал	Байгууллагын хэмжээнд бүртгэлийн суурь болон санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчим, журам, заавар, аргачлалыг тусгасан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" -ийг боловсруулж, албан ёсоор баталгаажуулан хэрэгжүүлээгүй зөрчил тогтоогдлоо.

Шалтгаан	Байгууллагын удирдлага болон ерөнхий нягтлан бодогчийн зүгээс санхүүгийн засаглал, бүртгэлийн тогтолцооны суурь баримт бичгийн ач холбогдлыг дутуу үнэлсэн; Санхүүгийн албаны зүгээс хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, мэргэжлийн арга зүйн баримт бичгийг боловсруулах санаачилга гаргаж ажиллаагүй.
Үр дагавар	Санхүүгийн тайлангийн эрсдэл: Санхүүгийн тайлан гаргах нэгдсэн бодлого, зарчим байхгүй тул ажил гүйлгээг бүртгэхдээ хувь нягтлан бодогчийн үзэмжээр хандах, улмаар тайлангийн үзүүлэлтүүд бодитой бус гарах, Олон улсын стандартаас зөрөх эрсдэлтэй. Хяналтгүй байдал: Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хувь хэмжээ, авлагын найдваргүйн нөөц байгуулах хугацаа, бараа материалын үнэлгээний арга зэрэг нь тодорхой бус байснаас санхүүгийн мэдээлэлд аудит хийх, түүнийг үнэн зөв гэж баталгаажуулахад хүндрэл үүснэ. Түүнчлэн энэ нь хуулийн дагуу санхүүгийн сахилга бат алдагдсан ноцтой зөрчилд тооцогдоно.
Зөвлөмж	Албан ёсоор батлах: Боловсруулсан бодлогын баримт бичгийг байгууллагын дарга/удирдлагын албан ёсны тушаалаар баталж, санхүүгийн үйл ажиллагаанд мөрдүүлж эхлэх.

Илрүүлэлт 4.2.8: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйл заалт Захирлын эд хөрөнгийн эрх үүрэг Зсаалт (Төрийн өмчит үйлдвэрийн газрын удирдлага)

Ноцтой байдлын зэрэглэл	ДУНД
Шалгуур / байх ёстой нөхцөл	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйл (Үйлдвэрийн газрын захирлын эрх, үүрэг, хариуцлага). Хуулийн 20.1.2 дахь заалт: Үйлдвэрийн газрын эргэлтийн болон үндсэн хөрөнгийг удирдах дээд шатны байгууллагын хяналт, зөвшөөрлийн дор захиран зарцуулах;Хуулийн 20.1.3 дахь заалт: Үйлдвэрийн газрын эд хөрөнгийг хадгалах, хамгаалах, ашиглах, бизнес төлөвлөгөөний дагуу үйлдвэрлэл, санхүүгийн үйл ажиллагааг үр ашигтай зохион байгуулах үүрэгтэй.</p> <p>Байх ёстой нөхцөл: Үйлдвэрийн газрын удирдлага нь тухайн жилийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө (бизнес төлөвлөгөө)-гөө урьдчилан боловсруулж, эрх бүхий байгууллага, удирдах дээд шатны байгууллагаар албан ёсоор батлуулж, батлагдсан төсвийн хүрээнд өмч хөрөнгийг захиран зарцуулах ёстой.</p>
Бодит байдал	Үйлдвэрийн газар нь 2024-2025 онуудын үйлдвэрлэл, санхүүгийн жилийн төлөвлөгөө (бизнес төлөвлөгөө)-гөө боловсруулж, эрх бүхий байгууллага, удирдах дээд шатны шатны цахим болон албан ёсны хурлаар хэлэлцүүлж батлуулаагүй үйл ажиллагаа явуулсан зөрчил тогтоогдлоо.

Шалтгаан	<p>□ Үйлдвэрийн газрын захирал/удирдлага нь хуулийн 20.1.3-т заасан бизнес төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг зохион байгуулах хуулиар хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн;</p> <p>□ Төлөвлөгөө батлуулах, дээд шатны байгууллагад танилцуулах ажлыг санхүү болон удирдлагын түвшинд идэвх санаачилга гарган зохион байгуулаагүй, санхүүгийн сахилга бат алдагдсан.</p>
Үр дагавар	<p>Эрх зүйн үр дагавар: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.2, 20.1.3 дахь заалтуудыг шууд зөрчсөн. Батлагдсан төлөвлөгөөгүйгээр өмч хөрөнгө, төсвийг захиран зарцуулсан нь эрх зүйн үндэслэлгүй зарцуулалтад тооцогдох эрсдэлтэй.</p> <p>Санхүүгийн үр дагавар: Үйлдвэрлэл, борлуулалт, зардлын хэмжээ нь дээд шатны байгууллагын хяналтаас гадуур хийгдсэн тул өмч хөрөнгө үр ашиггүй зарцуулагдсан байх өндөр эрсдэлтэй. Хуулийн 20.5-д зааснаар ажлын хариуцлага алдсанаас байгууллагад хохирол учруулсан бол захирал уг хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлөх эрх зүйн үр дагавар үүсэж болзошгүй.</p>
Зөвлөмж	<p>Хуулийн хэрэгжилтийг хангах: Цаашид Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан захирлын үүргийн дагуу дараа онуудын бизнес төлөвлөгөөг тухайн жилийн өмнөх оны 12 дугаар сард багтаан эрх бүхий байгууллагаар заавал батлуулж, зөвхөн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу эд хөрөнгийг захиран зарцуулж хэвших.</p>

5. ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧЛИЙН ШИЙДВЭРЛЭЛТ

Сэлэнгэ Барилга Захиалагч" ОНӨААТҮГ-ын 2024-2025 онуудын үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитаар нийт **349,372.1** мянган төгрөгийн 8 зөрчил илэрсэн. Үүнд: нийт **330,871.6** мянган төгрөгийн авлага (үүнд: дансны авлага **169,612.4** мянган төгрөг, бусад авлага **132,627.2** мянган төгрөг, татварын авлага **16,461.0** мянган төгрөг), НӨАТ-ын өглөг **12,171.0** мянган төгрөг, баримтгүй шатахууны зарцуулалт **18,500.5** мянган төгрөг тус тус илэрснээс санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн зөрчлийг таслан зогсоох **349,372.1** мянган төгрөгийн 2 албан шаардлага, зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх 6 зөвлөмж хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.

6. ДҮГНЭЛТ

5.1. Эерэг талууд

Аудитын явцад байгууллагын барилга угсралт, засвар үйлчилгээ, ашиглалт, санхүүгийн бүртгэл болон холбогдох анхан шатны баримт материалыг аудитад гарган өгч, илэрсэн асуудал, зөрчилтэй холбоотой мэдээлэл, тайлбарыг тухай бүр ирүүлсэн нь аудитын шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Мөн байгууллага нь барилгын үйл ажиллагаа, засвар арчлалт, ашиглалт хамгаалалт

болон үндсэн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх ажил, үйлчилгээг тасралтгүй зохион байгуулж ирсэн нь эерэг талтай байна.

5.2. Сайжруулах шаардлагатай гол асуудал

Сэлэнгэ Барилга Захиалагч" ОНӨААТҮГ-ын барилгын захиалагчийн хяналтын чиг үүрэг, төлөвлөгөөт хяналт-шинжилгээний үйл ажиллагаа тогтвортой хэрэгжиж байгаа боловч дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал, санхүүгийн болон гүйцэтгэлийн тооцоолол, тайлагналын чанарт системийн шинжтэй дутагдал (Е-Тайлан, Шилэн данс болон үр дүнгийн гэрээний дүгнэлт тасалдсан) илэрсэн тул дотоод хяналтын тогтолцоог "Сайжруулах шаардлагатай" гэж дүгнэв. (Дотоод аудитын дүгнэлтийн 2 дугаар түвшин – "Давтамжтай зөрчилтэй")

5.3. Аудитын ерөнхий дүгнэлт

Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тайлбар
САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ	Дотоод аудитын дүгнэлтийн 2 түвшний ангиллын дагуу 3-р түвшин буюу үйл ажиллагаа болон санхүүгийн удирдлага нь хууль тогтоомжийн дагуу заавал мөрдөх засаглалын болон бүртгэлийн суурь бүрдүүлээгүй, дотоод хяналт султай ажиллаж байгаа тул "Сайжруулах шаардлагатай" түвшинд байна."

7. ЗӨВЛӨМЖ

6.1. Эрх зүйн орчны шинэчлэл

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх дотоод журам, заавар, бодлогын баримт бичгийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн боловсруулж, эрх бүхий албан тушаалтнаар батлуулан мөрдүүлэх шаардлагатай. Үүнд дотоод хяналт шалгалтын бодлого, журам, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, төлбөр тооцоо, авлага өглөг барагдуулах журам, ажил хүлээлцэх журам, автомашин ашиглалт, шатахуун зарцуулалтын хяналтын журмыг тус тус боловсруулж баталгаажуулах нь зүйтэй.

6.2 Дотоод хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах

Байгууллагын хэмжээнд дотоод хяналт шалгалтын тогтолцоог бодитоор хэрэгжүүлж, санхүү, өмч хөрөнгө, төлөвлөлт, тайлагналын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавих механизмыг бүрдүүлэх шаардлагатай. Дотоод хяналтын ажлын төлөвлөгөөг жил бүр баталж, хэрэгжилтийг улирал тутам үнэлж, илэрсэн зөрчил, дутагдлын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг удирдлагын түвшинд хэлэлцэж хэвших нь зүйтэй.

Мөн хариуцсан албан тушаалтнуудын ажлын байрны тодорхойлолтод санхүүгийн сахилга бат, анхан шатны баримтын бүрдэл, тайлагнал, хөрөнгийн ашиглалттай холбоотой үүрэг, хариуцлагыг тодорхой тусгаж, биелэлтийг үнэлгээтэй холбох шаардлагатай.

6.3. Санхүү, бүртгэл, тайлагналын сахилга батыг хангах

Авлага, өглөгийн үлдэгдлийг сар бүр тооцоо нийлж баталгаажуулах, авлагын насжилтын тайлан гаргаж удирдлагад танилцуулах, хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай. НӨАТ болон бусад татвар, төлбөрийг хуульд заасан хугацаанд үнэн зөв тайлагнаж, төлөхөд анхаарч ажиллах нь зүйтэй.

Анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй ажил гүйлгээг санхүүгийн бүртгэлд тусгахгүй байх зарчмыг мөрдөж, шатахуун, автомашины ашиглалт, албан томилолт, худалдан авалт зэрэг зардлын гүйлгээнд урьдчилсан болон гүйцэтгэлийн хяналт тавих шаардлагатай. Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг тоон баримт, шийдвэр, гүйлгээний утга, хавсралтын хамт бүрэн, үнэн зөв, хугацаанд нь байршуулж хэвших нь зүйтэй.

6.4. Төлөвлөлт, тайлагнал, өмч хөрөнгийн удирдлагыг сайжруулах

Байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн гэрээ, үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөө буюу бизнес төлөвлөгөөг тухайн жилийн өмнөх хугацаанд боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулан, зөвхөн батлагдсан төлөвлөгөө, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулах шаардлагатай. Төлөвлөгөөний хэрэгжилтийг тодорхой шалгуур үзүүлэлтээр үнэлж, тайлант оны эцэст албан ёсоор дүгнүүлж хэвших нь зүйтэй.

Удирдлага, ерөнхий нягтлан бодогч, эд хариуцагч солигдох бүрд ажил, эд хөрөнгө, санхүүгийн баримт бичиг, авлага өглөгийн үлдэгдэл, үндсэн хөрөнгө, бараа материал, архивын баримтыг комисс томилон бүрэн тоолж, акт үйлдэн хүлээлцүүлж байх шаардлагатай. Ингэснээр өмч хөрөнгө дутах, үрэгдэх, хариуцлага тодорхойгүй болох эрсдэлийг бууруулах боломжтой.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

ДОТООД АУДИТОР

Д.ВАНЧИГМАА

ТАЙЛАН ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА

Т.ОДСҮРЭН

ТАНИЛЦСАН:

СЭЛЭНГЭ БАРИЛГА ЗАХИАЛАГЧИ
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА

Б.НОМИН

НЯГТЛАН БОДОГЧ

С.ӨНӨРЦЭЦЭГ

